

**ШУДРАГА ХЭРГИЙН ТӨЛӨӨ ТЭМЦЭГЧ**  
**(Ван Миний төрсний 75 жилийн ойд)**

Хятадын ард түмний үндэсний эрх чөлөөний тэмцлийн түүх нь хятадын ард түмний хүү, ХКН ба олон улсын коммунист хөдөлгөөний гарамгай зүтгэлтэн, пролетарийн интернационалч Ван Миний нэртэй салшгүй холбоотой юм.

Ван Мин (Чэнь Шаоюй) 1904 оны 5-р сарын 23-нд Аньхуй мужийн Цзиньчжай хотод багш хүний гэрт төржээ. Ван Мин 1924 онд Люань хотын хөдөө аж ахуйн дунд сургууль төгсөөд, Учань хотын худалдааны дээд сургуулийн бэлтгэл ангид оржээ. Тэрээр Учань хотод анх марксист зохиолуудтай танилцаж хувьсгалт үйл ажиллагаагаа тэндээс эхлэсэн ажээ.

1924 онд Хятадын Социалист Залуучуудын Эвлэлд, 1925 онд ХКН-д тус тус гишүүнээр элссэн байна. 1924-25 онуудад хятадын дэвшилт оюутны холбооноос эрхлэн гаргаж байсан «Ваньгуан», «Юйвань циннянь сюэхүй хүйкань» гэдэг сэтгүүлүүдийн редактораар ажиллаж байж. Тэдгээр сэтгүүлд Ван Мин өгүүлэл бичихдээ хятадын залуучуудыг улс орноо шинэ замаар шинэчлэн өөрчлөхийн төлөө тэмцэхийг байнга уриалж байжээ.

1925—27 оны Хятадын үндэсний хувьсгалын эхлэл болж Шанхай хотод 1925 оны 5-р сарын 30-нд гарсан империализмыг эсэргүүцсэн хөдөлгөөнийг дэмжсэн оюутны хөдөлгөөн, Ухань хотод өрнөхөд Ван Мин идэвхтэй оролцжээ.

1925 оны сүүлчээр Ван Мин ЗХУ-д суралцахаар явж Сунь Ятсены нэрэмжит Хятадын Хөдөлмөрчдийн Их Сургуульд суралцжээ. 1927 оны хавар Ван Мин эх орондоо буцаж ирээд мөн оны 4-5 сард хуралдсан ХКН-ын V их хуралд оролцож хурлын нарийн бичгийн дарга нарын газарт ажиллаж байжээ. Тэр ХКН-ын Төв Хорооны долоо хоног дутмын «Сяндао» сониныг эрхлэн гаргах ажилд идэвхтэй оролцож, хятадын хувьсгалын асуудлаар нилээд өгүүлэл бичиж нийтлүүлжээ.

Ван Мин 1927 оны 8-р сард ЗХУ-д буцаж очоод уг сургуульдаа үргэлжлэн суралцахын сацуу Коминтерны даалгавраар ЗХУ-ын Хувьсгалт цэргийн зөвлөлөөс бэлтгэсэн «Зэвсэгт бослого» гэдэг номыг хятад хэлнээ орчуулан оршил бичиж хэвлүүлсэн байна.

1928 оны зун Москвад болсон ХКН-ын VI их хурлын ажиллагаанд Ван Мин ажил хэрэгчээр оролцсон байна. Тэр 1929 оны 2-р сард нутагтаа буцаж нууц байдалд Шанхай хот, Цзянсу мужийн намын байгууллагууд болон ХКН-ын Төв Хорооны суртлын хэлтэст ажиллаж байв. 1929 онд «Хунци», 1930 онд «Лаодун» зэрэг сонинуудын эрхлэгчээр, 1931 онд Чжоу Эньлайн хамт «Наньчжэнь» сэтгүүлийг тус тус эрхлэн гаргаж байжээ.

Ван Мин тэр үед ХКН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоог толгойлж байсан Ли Лисаний жижиг хөрөнгөтний үндсэрхэг балмад чиг шугамыг шийдвэртэй эсэргүүцсээр байв. Ли Лисань, Мао Зэдүн нар Коминтерны зөвлөмжийг үл хайхран Хятад орны байдлыг буруу үнэлж, 1930 оны эхээр Хятадад хувьсгалын тохироо нэгэнт бүрдээд буй учир

даруйхан бослого, ажил хаялтыг эхлэх хэрэгтэй гэж шаардаж байжээ. Тэд «Хятадын хувьсгалыг ялалтанд хүргэхийн тулд ЗХУ ба империалист гүрнүүдийн хооронд дэлхийн дайныг өдөөн гаргаж дэлхийн хувьсгалыг зохиомлоор түргэвчлүүлэх санаатай байлаа.

Ван Мин жижиг хөрөнгөтний үндсэрхэг үзэлтэй Ли Лисань, Мао Зэдүн нарын баримталж буй үзэл бодлогын нийгмийн үндэс, оппортунист мөн чанарыг шүүмжилж хятадын хувьсгалын үндсэн асуудлуудыг тусгасан «Хоёр шугамын тэмцэл» гэдэг чухал зохиолоо 1931 оны 11-р сарын эхээр бичиж дуусгасан байна.

Марксизм-ленинизмийн сургаалыг хамгаалсан Ван Мингийн цуцалтгүй шургуу тэмцлийг ХКН-ын түүхэн зүй ёсоор үнэлдэг бөлгөө. 1931 оны 1-р сард хуралдсан ХКН-ын Төв Хорооны IV бүгд хурлаар Ван Минийг Хятадын Коммунист Намын Төв Хороо ба Улс төрийн товчооны гишүүн, Төв Хорооны нарийн бичгийн даргаар сонгосон ажээ.

Ван Мин 1931 оны 11-р сараас 1937 оны 11-р сарыг дуустал ХКН-аас Коминтерн-д суудаг төлөөлөгчөөр Москвад ажиллажээ. 1932-1943 онд Коминтерны Гүйцэтгэх Хорооны тэргүүлэгч гишүүн, 1932-1935 онд Коминтерны Гүйцэтгэх Хорооны улс төрийн нарийн бичгийн дарга нарын газрын гишүүн, 1935-1943 онд Коминтерны Гүйцэтгэх Хорооны нарийн бичгийн дарга нарын газрын орлогч гишүүнээр тус тус сонгогдон ажиллаж байв.

Ван Мин Коминтерн-д ажиллаж байхдаа олон улсын коммунист хөдөлгөөний гарамгай зүтгэлтнүүдтэй хамт тус байгууллагын онол-үзэл суртал, улс төрийн ажилд идэвхтэй оролцож Хятадын 1925-1927 оны хувьсгалын түүхэн туршлага мөн тухайн үе дэх ХКН-ын үйл ажиллагааг тал бүрээс нь шинжлэн судалж бодит дүгнэлт хийж байжээ. Тэрээр 1935 оны 8-р сард хуралдсан Коминтерны түүхт VII их хурлын бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэхэд идэвхтэй оролцсон бөгөөд тус их хуралд «Колони-хагас колони орнууд дахь хувьсгалт хөдөлгөөн ба коммунист намуудын тактикийн тухай» онол практикийн чухал ач холбогдолтой илтгэл тавьжээ. Уул илтгэлдээ Октябрийн социалист их хувьсгалын ялалт, ЗХУ-ын социалист бүтээн байгуулалт нь даян дэлхийн хувьсгалт хөдөлгөөний хөгжилтөд асар их далайцтай нөлөөлж байгааг тусган харуулснаас гадна Японы түрэмгийлэл ширүүсч байгаатай холбогдуулан Хятадын дотоод гадаад бодлогын асуудалд онцгой анхаарлаа төвлөрүүлсэн байна. Илтгэгч тухайн үед ХКН-ын удирдлагад гарч буй хувиа хичээсэн үндсэрхэг үзлийн алдааг тодорхой шүүмжилж, империализмыг эсэргүүцсэн ард нийтийн нэгдмэл фронт байгуулах тактикийг улам хөгжүүлэхийг ХКН-д уриалсан байдаг.

Ер нь Ван Мингийн гучаад оны үед бичсэн зохиол бүтээлд Хятад даяар үндэсний нэгдмэл фронт байгуулж, юуны өмнө харийн түрэмгийлэгч японы империализмын эсрэг тэмцэхийн чухлыг тодорхойлон зааж байсан нь тодорхой харагддаг.

Ийм ч учраас 1937 оны 12-р сард болсон ХКН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны өргөтгөсөн зөвлөлгөөн дээр н. Ван Мины олон талт үйл ажиллагааг зүй ёсоор өндөрт үнэлж байжээ.

1937 оны 11-р сард Ван Мин эх орондоо буцаж очоод ХКН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны гишүүн, нарийн бичгийн даргын хувьд хэд хэдэн орон нутгийн намын товчоо, ХКН-ын Төв Хорооны хэлтэс, комиссуудын ажлыг удирдаж байхдаа Коминтерны удирдлага заалтыг биелүүлэхийн төлөө хамгаас түрүүн чармайж байсан аж. 1938—1939 онд Ван Мин ХКН-ын Төв Хорооны нэгдмэл фронтын хэлтсийг толгойлж, ХКН-ын Төв Хорооны Төв хятадын товчоог удирдаж байсан ажээ.

Нам ба ард түмний дотор Ван Мин үлэмж нэр хүндтэй болж байсан нь Мао Зэдүний дургүйг ихэд хүргэж байжээ. Мао Зэдүн тэр үед ХКН-ын удирдлагыг булааж, өөрийн үзэл санааг ХКН-д тулган хүлээлгэхийг хичээн эхлэж байсан тул тууштай марксист, интернационалч Ван Минийг үзэн ядаж элдэв аргаар эсэргүүцэж байжээ.

1941—1945 оны «суртал цэгцлэх» хөдөлгөөний үед Мао Зэдүн түүний хамсаатан нар «Ван Миний хоёр чиг шугам» гэдэг ном хэвлэн гаргаж, түүндээ Ван Мин 1931—1934 онуудад «Зүүн оппортунист», 1937—1938 онуудад «Баруун оппортунист» чиг шугам баримталж байсан мэтээр бичжээ. Ийнхүү Маогийнхан Ван Минийг шүүмжлэхийн сацуу дэлхийн хувьсгалд гүйцэтгэж байгаа Коминтерны түүхэн ач холбогдлыг бууруулж, хятадын «өвөрмөц» үндсэрхэх үзлийг дэвэргэж бас 20—30 онуудад ХКН-ын жанжин шугамыг боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэж байсан намын шилдэг бусад зүтгэлтэн нарын эсрэг тэмцэж эхэлжээ. Түүгээр ч барахгүй 1941 оны 9-р сараас Ленинизмийн эсрэг «Мао Зэдүнизм» гэгчийг гаргаж ирэхийг санаархах болсон байна. Жишээ нь: 1941 онд нэг өдөр Мао Зэдүн Ван Минтэй уулзаж ярилцахдаа Маркс-марксизмтай, Ленин ленинизмтэй байхад бид яагаад Мао Зэдүнизм байж болохгүй билээ гэж шоглон асуужээ. Тэгэхэд нь Ван Мин Троцкий, Чэнь Дусю хоёр өөрийн буруу үзэлтэй тохирсон «изм»-тэй байх гэж оролдоод буруутсан билээ гэхэд Мао Зэдүн би Маозэдүнизмтэй бий болгосноор марксизмаас ухрахгүй, харин ленинизмийг хүлээн зөвшөөрөхгүй, яагаад гэвэл ленинизм бол оросын марксизм бөгөөд оросын хувьсгалын тодорхой практикийг марксизмын үзэл санаанд тохируулсан юм. Харин миний ярьдаг маозэдүнизм бол хятадын марксизм, тэгээд ч хятадын хувьсгалын практикийг марксизмын онолтой нэгтгэх болно гэж ичгүүр сонжуургүй ярьж байжээ. Түүнийг нь Ван Мин няцааж хэлэхдээ «Бид—коммунистууд үзэхдээ ленинизм бол империализм, пролетарийн хувьсгалын үеийн марксизм бөгөөд шинэ эрин үед хөгжиж буй марксизм бол ленинизм юм<sup>1</sup> гэжээ.

Чухам ингэж Мао Зэдүн дөчөөд оны эхээр явуулсан «суртал цэгцлэх» хөдөлгөөнөөрөө ХКН-ын доторхи эрүүл хүчнийг дарах, намын үзэл суртал, онол болон зохион байгуулалтын зарчмыг өөрчлөн ХКН-ыг өөрийн үзэл санаа буюу «маозэдүнизм»-ын нэвтрүүлэгч болгох гэж оролдож байсан нь дээрхээс тодорхой байна.

Ван Мин ХКН-ын VII, VIII их хурлаар ХКН-ын Төв Хорооны гишүүнээр улиран сонгогджээ.

БНХАУ байгуулагдсаны дараа Ван Мин Ардын төв засгийн газрын гол гол ажилд идэвхтэй оролцож ялангуяа хуулийн төсөл боловсруулах ажлыг удирдаж байжээ.

1949 оны 3-р сард хуралдсан ХКН-ын Төв Хорооны 7 дахь удаагийн сонгуулийн II бүгд хурал дээр Ван Мин хэлсэн үгэндээ Мао Зэдүн социалист хувьсгал, социалист бүтээн байгуулалтаас хэрэг дээрээ татгалзаж байгааг илрүүлэн шүүмжилжээ.<sup>2</sup> Үүний дараа 1950 оны 6-р сард болсон ХКН-ын Төв Хорооны 7 дахь удаагийн сонгуулийн III бүгд хурал Мао Зэдүний шаардлагаар «нөхөр Ван Миний тухай шийдвэр» зориуд гаргаж түүнээс «буруугаа хүлээхийг» шаардсан ажээ.

1956 оны 2-р сараас эхлэн Ван Мин ЗХУ-д эмчлүүлж байх хугацаандаа БНХАУ-ын хөдөлмөрчдийн социалист байгуулалтандаа олж буй амжилтыг ихэд сонирхож байснаас гадна Мао Зэдүн болон түүний бүлгийнхний баримталж буй «онцгой чиг шугамын хор уршгийг ойлгож, Мао Зэдүний онол практикт маш болгоомжтой бөгөөд шүүмжлэлтэй хан-

<sup>1</sup>Ван Мин «Чжунгун бань шицзи ю паньту Мао Зэдүн» (Хятадын Коммунист Намын хагас зуун жил ба Мао Зэдүний урвалт), М.. 1975, 13—14-р тал.

<sup>2</sup>Мөн зохиол, 150—151, 155—158-р тал.

даж байв. Тэрээр «Ленин ленинизм, Хятадын хувьсгал» гэдэг номондоо «Мао Зэдүн 60-аад оноос эхлэн өөрийн ленинч бус, зөвлөлтийн эсрэг, хагалан бутаргагч, хорлон сүйтгэгч үйл ажиллагаагаараа дэлхий социалист хамтын нөхөрлөлийн орнууд, олон улсын коммунист ажилчны хөдөлгөөн болон Ази, Африк, Латин Америкийн ард түмний империализмын эсрэг хөдөлгөөнд их хохирол учруулж байна...Тэр ингэснээрээ америкийн ба бусад империалистуудад их дэмжлэг үзүүлж байгаагаар барахгүй мөн ХКН, Хятадын ард түмний үндсэн ашиг сонирхлыг хөсөрдүүлж байна»<sup>1</sup> гэжээ.

Ван Мин бичсэн зохиолууддаа Маогийн бүлгийнхний их гүрний дээрэнгүй үзэл, түүний ленинч бус, социализмын эсрэг чиглэсэн бодлого болон түүний хор уршгийг марксист-ленинист онолын үүднээс шүүмжлэн няцааж байв.

Ван Мин 1969—1974 онд бичсэн зохиолууддаа ХКН-ын түүх, Хятадын хувьсгалын түүхийг үнэн зөвөөр нь шинжлэн судалж, Маркс, Лениний сургаалаас маогийнхан хэрхэн татгалзаж байгааг дүгнэн бичсэнээс гадна Мао Зэдүн марксизм-ленинизм, социализмын үйл хэргээс бүрмөсөн урван тэрсэлснийг хөдлөшгүй баримтаар нотолж, түүний нийгмийн үндсийг шинжлэн дүгнэхэд ихээхэн цаг, хүч зориулжээ. Тэрээр амьдралынхаа сүүлчийн хэсэгт харгис маоизмтай эвлэршгүй тэмцэж байгаад нас эцэслэсэн билээ. Хамгийн сүүлд «Хятадын Коммунист Намын хагас зуун жил ба Мао Зэдүний урвалт» гэдэг зохиолыг бичиж дуусгасан ба энэхүү зохиолыг 1975 онд дэлхийн олон улсын хэлээр хэвлэжээ.

Тууштай марксч-ленинч, интернационалч коммунист Ван Миний амьдрал, үйл ажиллагаа нь Хятадын ард түмний үндэсний эрх чөлөө тусгаар тогтнолын хувьсгалт тэмцэл хийгээд социалист бүтээн байгуулалттай салшгүй холбоотой юм. Гэтэл одоогийн хятадын маоист эрх баригчид Ван Миний яруу алдрыг яаж ч гутаахыг оролдовч хятадын ард түмэн ба дэлхий коммунист хөдөлгөөний өмнө түүний байгуулсан үлэмжийн гавьяаг баллаж чадахгүй.

**Ж. Баясах**

<sup>1</sup> Ван Мин. «Ленин, ленинизм и китайская революция», М., 1970, 23—24-р тал.